

16 МЕССИА МЭНДЭЛСЭН НЬ

16.1 Мосегийн адил эш үзүүлэгч илгээх

¹¹Учир нь Эзэн БУРХАН ийнхүү айлдаж байна. “Харагтун. Би Өөрийн хонинуудыг Өөрөө бэдэрч, тэднийг олох болно. ¹²Тараагдсан хонинуудынхаа дунд байхдаа хоньчин өөрийн сүрэгтээ санаа тавьдгийн адил, тийнхүү Би Өөрийн хонинуудын төлөө санаа тавьж, үүлтэй болон бүрэнхий өдрөөр тарсан хамаг газруудаас нь тэднийг аврах болно.

¹³Би ард түмнүүдээс тэднийг гаргаж, улсуудаас тэднийг цуглуулж, тэднийг уугуул нутагт нь аваачна. Израилийн уулс, урсгалуудын дэргэд болон тэр нутаг дахь хүмүүс оршин буй хамаг газруудад Би тэднийг тэжээх болно.

¹⁴Би тэднийг сайн бэлчээрт тэжээх бөгөөд тэдний бэлчээрлэх газар нь Израилийн өндөр уулан дээр байх болно. Тэнд тэд сайн бэлчээрт хэвтэж, Израилийн уулс дээр арвин бэлчээрт идээшлэх болно.

¹⁵Би Өөрийн сүргийг тэжээж, Би тэднийг хотлуулна” гэж Эзэн БУРХАН тунхаглаж байна. ¹⁶“Би гээгдсэнийг хайж, тараагдсаныг буцааж, гэмтсэнийг боох бөгөөд өвчтэйг нь тэнхрүүлэх болно. Харин тарган болон тэнхлүүнийг нь Би устгах болно. Би тэднийг шүүлтээр тэжээнэ. (Езекиел 34:11-16 АБ 2004)

²³Дараа нь Би тэдний дээр нэгэн хоньчинг буюу Өөрийн зарц Давидыг томилж, тэрээр тэднийг тэжээх болно. Тэр өөрөө тэднийг тэжээж, тэдний хоньчин болно. ²⁴ЭЗЭН Би тэдний Бурхан болж, Миний зарц Давид тэдний дунд ноён болно. ЭЗЭН Би айлдсан билээ. (Езекиел 34:23-24 АБ 2004)

¹⁵ЭЗЭН Бурхан чинь чиний төлөө та нарын дундаас, ах дүү нарын чинь дотроос над шиг нэгэн эш үзүүлэгчийг гаргаж ирнэ. Та нар түүнийг сонсогтун (Дэд хууль 18:15 АБ 2004)

²²Дараа нь Есүс шавь нартайгаа Иудей нутагт очиж, тэдэнтэй хамт тэнд байж, баптисм хүртээж байлаа. ²³Мөн Иохан

Салимын ойролцоо Аенонд баптисм хүртээж байв. Учир нь тэнд ус ихтэй ажээ. Хүмүүс ирж баптисм хүртэж байлаа. ²⁴Учир нь Иохан хараахан шоронд хоригдоогүй байв.

²⁵Тэр цагт Иоханы шавь нар болон нэгэн Иудей хүний хооронд ариусгалын талаар маргаан үүсжээ. ²⁶Тэд Иохан уруу ирж-Рабби, Иорданы тэртээ Тантай хамт байсан, таны гэрчилж байсан Тэр нь одоо баптисм хүртээж байна. Бүгд Түүн уруу очиж байна гэсэнд ²⁷Иохан -Тэнгэрээс өөрт нь өгөгдөөгүй л бол хүн юуг ч хүлээн авч чадахгүй. ²⁸“Би бол Христ биш, харин Түүний урьд илгээгдсэн нэгэн мөн” гэж миний хэлснийг гэрчлэгч нь та нар өөрсдөө билээ.

²⁹Бэр авагч нь шинэ хүргэн мөн. Харин зогсоод чагнагч найз нь шинэ хүргэний дуунд үлэмж баясдаг. Миний энэ баяр хөөр ч дүүрэн болов. ³⁰Тэр өсөж, харин би буурах ёстой гэж хэлэв.

³¹Дээрээс ирэгч нь бүхний дээр байдаг. Газраас ирэгч нь газрынх бөгөөд газрын тухай л ярьдаг. Тэнгэрээс ирэгч нь [бүхний дээр байдаг]. ³²Тэр үзсэн, сонссоноо гэрчилдэг боловч хэн ч Түүний гэрчлэлийг хүлээн авдаггүй. ³³Түүний гэрчлэлийг хүлээн авсан хүн Бурхан бол үнэн гэж батлан тамгалсан юм.

³⁴Бурханаас илгээгдсэн Тэр Бурханы үгийг айлддаг. Учир нь Бурхан Сүнсийг хэмжээлшгүйгээр өгдөг. ³⁵Эцэг нь Хүүгээ хайрлан, Түүний гарт бүх юмсыг өгсөн юм. ³⁶Хүүд итгэдэг хүн мөнх амьтай. Харин Хүүд итгэдэггүй хүн мөнх амийг үзэхгүй. Харин Бурханы уур хилэн тэр хүн дээр байдаг.
(Иохан 3:22-36 АБ 2004)

[] Түүнтэй уулзах цаг айсуу, та бэлэн үү?

[] Та Түүний хоньдын нэг мөн үү?

[] Мосе шиг эш үзүүлэгч гэж хэн болохыг та мэдэх үү?

[] Та Бурхан үнэнийг л ярьдаг гэдгийг гэрчилдэг үү?

[] Бурхан бүх "эрх мэдэл", "амийг" Есүс Христэд өгсөн гэдэгт та итгэдэг үү?

[] Таньд Христ доторх амь байдаг уу?

16.2 "Их Эзэний замыг бэлтгэгтүн" гэж хашгирах дуу

³Хашхирагч нэгний дуу “Зэлүүд талд ЭЗЭНд зориулан зам засагтун. Манай Бурханд зориулан цөлд их замыг тэгш болгогтун. ⁴Хөндий бүр өргөгдөж,уул толгод бүр нам болж, барзгар газар нь тэгш, гүдгэр газар тэгш хөндий бологтун. ⁵Дараа нь ЭЗЭНий алдар илэрхийлэгдэж, бүх махан бие хамтдаа үзнэ. Учир нь ЭЗЭНий ам айлдлаа” гэв. (Исаиа 40:3-5 АБ 2004)

⁶Бурханаас илгээгдсэн нэгэн хүн байсан ба нэр нь Иохан юм. ⁷Иохан гэрлийн тухай гэрчилж, бүгдийг өөрөөрөө дамжуулан итгүүлэхийн тулд гэрчлэл хийхээр иржээ. ⁸Тэр бол өнөөх гэрэл байсангүй, харин гэрлийн тухай гэрчлэхээр ирсэн ажээ. ⁹Ертөнцөд ирэн хүн бүрийг гэгээрүүлдэг жинхэнэ гэрэл байв. ¹⁰Тэр ертөнцөд байсан. Ертөнц Түүгээр бий болсон атал, ертөнц Түүнийг таньсангүй. ¹¹Тэр өөрийнхөндөө ирсэн боловч, өөрийнхөн нь Түүнийг хүлээн авсангүй. (Иохан 1:6-9 АБ 2004)

¹⁹Иоханаас “Та хэн бэ?” гэж асуулгахаар иудейчүүд Иерусалимаас тахилч нар болон левичүүдийг илгээхэд түүний хэлсэн гэрчлэл ийм байлаа. ²⁰Тэр үгүйсгэлгүй хүлээн зөвшөөрч -Би Христ биш гэж зөвшөөрөн хэллээ. ²¹Тэд түүнээс -Тэгвэл та хэн юм бэ? Та Елиа юм уу? гэж асуухад, тэр -Би биш гэсэнд, -Та өнөөх Эш үзүүлэгч үү? гэхэд тэр -Үгүй гэлээ. ²²Тэгтэл тэд түүнд -Та хэн бэ? Биднийг явуулсан хүмүүст бид хариу өгөх учиртай. Та өөрийнхөө тухай юу хэлэх вэ? гэв. ²³Иохан -Эш үзүүлэгч Исаиагийн айлдсан “ЭЗЭНий замыг шулуун болгогтун” гэж цөлд хашхирах нэгний дуу бол би билээ гэж хэлэв. ²⁴Фарисайчуудын явуулсан хүмүүс бас байлаа. ²⁵Тэд түүнээс -Хэрэв та Христ биш, Елиа ч биш, өнөөх Эш үзүүлэгч ч биш юм бол яагаад баптисм хүртээнэ вэ? гэж асуусанд ²⁶Иохан -Би усаар баптисм хүртээдэг, харин дунд чинь та нарын үл таних Нэгэн зогсож байна. ²⁷Миний араас Ирэгч нь Тэр бөгөөд Түүний шаахайн сурыг ч тайлах нь надад зохисгүй гэж хэлэв. ²⁸Энэ явдал

Иоханы баптисм хүртээж байсан Иордан голын тэртээх Бетанд болсон юм. (Иохан 1:19-28 АБ 2004)

¹Тэр өдрүүдэд баптисм хүртээгч Иохан ирж, Иудейн цөлд сургаал айлдаж,²-Гэмшицгээ! Тэнгэрийн хаанчлал ойрхон байна гэж байлаа. ³Яг түүний тухай эш үзүүлэгч Исаиа “Цөлд хашхирагч нэгний дуу, “Эзэний замыг бэлтгэцгээ, Түүний замыг шулуун болгоцгоо” гэнэ”⁴Иохан тэмээний ноосон дээл өмсөж, суран бүс бүсэлсэн байв. Хоол хүнс нь царцаа, зэрлэг зөгийн бал байсан аж. ⁵Тэгэхэд иерусалимынхан, бүх Иудей мөн Иордан хавийн бүх газар нутгийнхан түүн уруу ирж байлаа. ⁶Тэд нүглээ улайгаад, Иордан голд түүгээр баптисм хүртэж байв. ⁷Харин фарисайчууд болон садукайчуудаас олон хүн баптисм хүртэхээр ирж буйг тэр хараад, тэдэнд -Хорт могойн удам аа, ирэх уур хилэнгээс зугт гэж хэн та нарт сануулсан юм бэ? ⁸Тийм бөгөөс гэмшилд зохистой үр жимс гарга. ⁹“Абрахам бол бидний эцэг” гэж дотроо бүү бод. Би та нарт хэлье, Бурхан энэ чулуунуудыг ч Абрахамын хүүхдүүд болгож чадна. ¹⁰Моддын үндсэнд сүх хэдийн зоогджээ. Иймээс сайн үр жимс ургуулдаггүй аливаа мод цавчуулан, галд хаягдах болно. ¹¹Миний хувьд гэвэл, гэмшлийн чинь төлөө би та нарт усаар баптисм хүртээдэг. Харин миний араас Ирэгч надаас илүү хүчтэй бөгөөд Түүний шаахайг тайлах нь ч надад зохисгүй. Тэр та нарт Ариун Сүнсээр хийгээд галаар баптисм хүртээнэ. ¹²Түүний гарт нь шигшүүр байна. Тэр үтрэмээ гүйцэд цэвэрлээд, Өөрийн улаан буудайг саравчинд овоолж, харин хивэг хальсыг нь унтаршгүй галаар шатаана гэж хэлэв. (Матай 3:1-12 АБ 2004)

¹Бурханы Хүү Есүс Христийн сайн мэдээний эхлэл. ²Эш үзүүлэгч Исаиагийн номд бичигдэхдээ “Харагтун. Би Чиний өмнө замыг чинь бэлдэх элчээ илгээнэ. ³Цөлд хашхирагч нэгний дуу “ЭЗЭНий замыг бэлтгэгтүн, Түүний замыг шулуун болгогтун” гэнэ”⁴баптисм хүртээгч Иохан цөлд ирж, нүглийн уучлалын төлөөх гэмшлийн баптисмыг тунхаглаж байв. ⁵Бүх Иудей нутгийнхан, Иерусалимын бүх хүн Иохан уруу очиж нүглээ хүлээн зөвшөөрч, Иордан голд түүнээс баптисм хүртэж байлаа. ⁶Иохан тэмээний ноосон хувцас

өмсөж, суран бүс бүсэлжээ. Тэр царцаа, зэрлэг зөгийн балаар хооллодог байжээ. ⁷Тэр тунхаглаж -Надаас хүчирхэг Нэгэн араас минь ирж байна. Би доош бөхийж, Түүний шаахайн сурыг тайлах нь зохисгүй. ⁸Би та нарт усаар баптисм хүртээсэн, харин Тэр та нарт Ариун Сүнсээр баптисм хүртээнэ гэв. (Марк 13:1-8 АБ 2004)

[] Бүх хүмүүс Эзэний алдрыг харсан бөгөөд харах болно. Та харсан уу?

[] Иохан бол цөл дэхь нэгэн дуудлагын дуу хоолой гэдэгт та итгэдэг үү?

[] Иохан Гэрлийн тухай эш үзүүллэгийг биелүүлсэн гэдэгт та итгэдэг үү?

[] Бид "нигүүлслийн цагт" амьдарч байгааг та мэдэх үү?

16.3 Абрахамын удам

ЭЗЭН Абрамд айлдсан нь
-Чи төрсөн нутгаа,
Төрөл садангаа,
Эцгийнхээ гэрийг орхиж,
Миний чамд зааж өгөх газар уруу яв.
Би чамайг агуу үндэстэн болгож,
Чамайг ерөөн,
Алдар нэрийг чинь агуу болгоно.
Тэгээд чи ерөөлийн үндэс болно.
Чамайг ерөөгчдийг Би ерөөж, Чамайг хараагч нэгнийг Би хараана.
Газар дэлхий дээрх бүх үндэстэн чамаар дамжуулан ерөөгдөнө гэв. (Эхлэл 12:1-3 АБ 2004)

Бас чи Миний үгийг дуулгавартай дагасан учир газар дэлхийн бүх үндэстэн чиний үрсээр дамжуулан ерөөгдөх болно” гэв. (Эхлэл 22:18 АБ 2004)

Абрахамын удам, Давидын удам, Есүс Христийн угийн ичиг. (Матай 1:1 АБ 2004)

Амлалтууд нь Абрахамд болон түүний үрд айлдагдсан юм. Тэр “Үрст” гэж олны талаар хэлээгүй, харин ганцын тухай “Чиний үрд” гэж айлдсан. Тэр бол Христ мөн. (Галат 3:16 АБ 2004)

16.4 Иуда овгоос

Шилог иртэл хааны таяг Иудагаас салахгүй. Захирагчийн шийдэм түүний хөлийн хоорондоос салахгүй. Бүх хүн түүнийг дуулгавартай дагах болно. (Эхлэл 49:10 АБ 2004)

Есүс гучаад настай байхдаа Өөрийн үйлчлэлийг эхэлсэн бөгөөд хүмүүсийн боддогоор, Тэр бол Иосефын хүү, Иосеф нь Елигийн, (Лук 3:23 АБ 2004)

Нахшон нь Амминадабын, Амминадаб нь Админы, Админ нь Рамын, Рам нь Хезроны, Хезрон нь Перезийн, Перез нь Иудагийн, (Лук 3:33 АБ 2004)

Учир нь бидний Эзэн бол Иудагаас гаралтай нь тодорхой бөгөөд тэр овогт хамаатай тахилч нарын талаар Мосе юу ч хэлсэнгүй. (Еврей 7:14 АБ 2004)

[] Абрахамаар дамжуулан Бурхан ерөөлийн гэрээг өгсөн бөгөөд энэ нь болзолтой. Та эдгээр нөхцөл байдал юу болохыг мэдэх үү?

[] Абрахам олон хүүтэй байсан. Бурхан яагаад ганц үрийг голчилсонг та мэдэх үү?

16.5 ДАВИДЫН ГЭР

¹²Чиний өдрүүд дуусаж, чи эцэг өвгөдийнхөө хамт нойрсох үед Би чамаас гарах үрийг чинь чиний дараа босгож, түүний хаанчлалыг тогтооно. ¹³Тэр Миний нэрийн төлөө өргөө босгож, Би түүний хаанчлалын суудлыг мөнхөд тогтооно. ¹⁴Би түүний эцэг болж, тэр Миний хөвгүүн болно. Тэр гэм бурууг үйлдвэл, Би хүний таяг, хүний хөвгүүний ташуураар түүнийг засан хүмүүжүүлнэ. ¹⁵Гэвч чиний өмнөөс Миний зайлуулж өгсөн Саулаас Би хайр энэрлээ авсны адил Миний хайр энэрэл түүнээс салахгүй. ¹⁶Чиний гэр болон чиний хаанчлал Миний өмнө мөнхөд үргэлжилж, чиний хаан ширээ мөнхөд тогтоно” гэв” хэмээгээрэй гэж айлдав. (2 Самуел 7:12-16 АБ 2004)

⁵“Харагтун, Би Давидад зөв шударга Мөчир ургуулах өдрүүд ирж байна” гэж ЭЗЭН тунхаглаж байна.“Тэрээр хаан мэт

захирч, мэргэн ухаанаар үйлдэж, энэ газар нутагт шударга ёсыг болон зөв шударгыг үйлдэнэ. (Иеримеа 23:5 АБ 2004)

²⁷Би мөн түүнийг ууган хүү, Газар дэлхийн хаадаас хамгийн дээд хаан болгоно. (Дуулал 89:27 АБ 2004)

¹Абрахамын удам, Давидын удам, Есүс Христийн угийн бичиг.

²Абрахам Исаакийн эцэг, Исаак Иаковын эцэг, Иаков Иудагийн болон ах дүүсийнх нь эцэг болой. ³Иуда нь Перез, Зера нарын эцэг бөгөөд тэд Тамараас төржээ. Перез Хезроны эцэг, Хезрон Рамын эцэг, ⁴Рам Амминадабын эцэг, Амминадаб Нахшоны эцэг, Нахшон Салмоны эцэг юм. ⁵Салмонд Рахабаар Боаз, Боазд Рутаар Обед төржээ. Обед бол Иессийн эцэг, ⁶Иесси нь Давид хааны эцэг билээ. Уриагийн эхнэрээс Давидад Соломон төрсөн ⁷бөгөөд Соломон Рехобоамын эцэг, Рехобоам Абиагийн эцэг, Абиа Асагийн эцэг юм. ⁸Аса Иехошафатын эцэг, Иехошафат Иорамын эцэг, Иорам Уззиагийн эцэг, ⁹Уззиа Иотамын эцэг, Иотам Ахазын эцэг, Ахаз Хезекиагийн эцэг, ¹⁰Хезекиа Манассегийн эцэг, Манассе Амоны эцэг, Амон Иосиагийн эцэг юм. ¹¹Вавилон уруу цөлөгдөх үед Иосиад Иекониа болон ах дүүс нь төржээ.

¹²Вавилон уруу цөлөгдсөний дараа Иекониад Шеалтиел, Шеалтиелд Зеруббабел нар төрөв. ¹³Зеруббабел Абихудын эцэг, Абихуд Елиакимын эцэг, Елиаким Азорын эцэг, ¹⁴Азор Задокийн эцэг, Задок Ахимын эцэг, Ахим Елиудын эцэг, ¹⁵Елиуд Елеазарын эцэг, Елеазар Маттаны эцэг, Маттан Иаковын эцэг юм. ¹⁶Иаков бол Христ хэмээгддэг Есүсийг төрүүлсэн Мариагийн нөхөр Иосефын эцэг болой.

¹⁷Ийнхүү Абрахамаас Давидыг хүртэл бүгд арван дөрвөн үе, Давидаас Вавилон уруу цөллөгдөх хүртэл арван дөрвөн үе, Вавилон уруу цөлөгдсөнөөс Христийн үеийг хүртэл арван дөрвөн үе байв. (Матай 1:1-17 АБ 2004)

[] Бурхан Мосед "Би бол Абрахам, Исаак, Иаковын Бурхан" гэж хэлсэн. Яагаад гэдгийг та мэдэх үү?

[] Есүс Христ бол Абрахамын хүү Иудагийн овгийн Давидын хүү, амлагдсан нэгэн. Энэ үнэн гэдэгт та итгэдэг үү?

16.6 Мессиа: Бие махбодийн дүрслэл

¹³Үзэгтүн, Миний зарц ухаалгаар үйлдэнэ. Тэр өргөмжлөгдөж, хүндэтгэгдэн үлэмж магтагдана. ¹⁴Түүний төрх нь аливаа хүнийхээс, Түүний хэлбэр нь хүний хөвгүүдийнхээс илүүгээр зэрэмдэг байсан учраас олон хүмүүс чамайг үзээд хирдхийв. ¹⁵Ийнхүү Тэр нь олон үндэстнийг бутарган, Түүнээс болж хаад амаа хамхина. Учир нь тэдэнд хэлээгүй юмыг тэд харж, тэдэнд сонсгоогүй юмыг тэд ойлгоно. (Исаиа 52:13-15 АБ 2004)

¹Бидний мэдээнд хэн итгэсэн бэ? ЭЗЭНий мутар хэнд илэрхийлэгдсэн бэ? ²Учир нь Тэр Түүний өмнө нялх нахиа мэт, хуурай газраас гарсан үндэс мэт ургасан. Түүнд хэлбэр дүрс, цог жавхлан байхгүй. Бид Түүнийг харья гэсэн ч бидний анхаарлыг татахуйц дүр төрх алга. ³Тэр үзэн ядагдаж, хүмүүсээр орхигдов. Тэр уй гашууны хүн бөгөөд өвчин зовлонг мэдсэн. Бид нүүрээ Түүнээс нуусан. Тэр үзэн ядагдаж, бид Түүнийг хүндэтгээгүй. (Исаиа 53:1-3 АБ 2004)

Хаадын Хаан ба Эзэдийн Эзэн, Бүтээгч Бурхан, Төгс Хүчит Бурхан, Эхлэл ба Төгсгөл, Альфа, Омега нь дэлхий дээр хүүхдүүдийнхээ төлөө толгой хоргодох ямар ч газаргүй амьдарч байсан.

[] Та гомдоллохгүйгээр Түүний тушаалыг дагаж байна уу?

16.7 Онгон бүсгүйгээс төрсөн Мессиа

Дараа нь ЭЗЭН Ахазтай дахин ярьж, ийнхүү айлдав. ¹¹Өөртөө Бурхан ЭЗЭНээсээ тэмдэг гуйгтун. Үхэгсдийн орон шиг гүн, эсвэл тэнгэр шиг өндөр хүсэлт тавь. ¹²Харин Ахаз - Би гуйхгүй, ЭЗЭНийг ч сорихгүй гэжээ. ¹³Исаиа -Одоо сонсогтун. Давидын гэр ээ! Хүмүүсийн тэвчээрийг сорих нь чамд багадаад, одоо миний Бурханы тэвчээрийг мөн сорих гэж байна уу?

¹⁴Тийм учраас Эзэн Өөрөө чамд нэгэн тэмдэг өгнө. Үзэгтүн! Нэгэн онгон бүсгүй хүүхэдтэй болж, хүү төрүүлээд, Түүнийгээ “Иммануел” гэж нэрлэнэ. ¹⁵Тэр хүү муугаас татгалзаж, сайныг сонгохоо мэдэх үедээ ээдэм болон зөгийн бал иднэ. ¹⁶Учир нь хүүг муугаас татгалзан, сайныг сонгохоо

мэдэхээс өмнө чиний айдаг хоёр хааны нутаг мартагдах болно. (Исаиа 7:15-16 АБ 2004)

³Та үндэстнийг олшруулан, тэдний баяр хөөрийг нь ихэсгэнэ. Хүмүүс олзоо хуваах үед баярладаг шиг, тэд Таны оршихуйд ургац хураан баярлалдана. ⁴Учир нь Мидианы өдрийнх шиг тэднийг дарангуйлагчийн ташуур болох тэднийг дарамтлах буулга, мөрөн дээрх дөнгийг нь Та эвдэнэ. ⁵Тулалдаанд цэрэг хүний өмссөн гутал бүрийг, цусанд өнхрүүлсэн хувцас бүхнийг галын түлш мэт шатаана.

⁶Учир нь бидний төлөө хүүхэд төрж, бидэнд хүү өгөгдөнө. Засаглал Түүний мөрөн дээр байх болно. Түүний нэрийг Гайхамшигт Зөвлөгч, Хүчит Бурхан, Мөнхийн Эцэг, Энхийн Жонон гэж дуудна. ⁷Давидын сэнтий, түүний хаанчлалд шударга ёс, үнэн зөвийг үеийн үед тогтооход, Түүний засаглал болон энх амгалан нь одоогоос үүрд мөнхөд байх болно. Түмэн цэргийн ЭЗЭНий зүтгэл үүнийг хэрэгжүүлнэ. (Исаиа 9:3-7 АБ 2004)

¹⁸Есүс Христ ингэж мэндэлжээ. Есүсийн эх Мариа Иосефтой сүй тавиад, дэр нийлэхээсээ өмнө хэвлийдээ Ариун Сүнсээр хүүхэдтэй болсон байлаа. ¹⁹Нөхөр нь болох Иосеф зөвт хүн байсан бөгөөд Мариаг гутамшиг болгохыг үл хүссэн тул түүнээс нууцаар салах бодолтой байжээ. ²⁰Харин түүнийг тийн бодож байх үед Эзэний тэнгэр элч зүүдэнд нь үзэгдэж, - Давидын хүү Иосеф оо, Мариаг эхнэрээ болгохоос бүү эмээгтүн. Учир нь түүнд олдоод байгаа нь Ариун Сүнснийх юм. ²¹Түүнийг Хүү төрүүлэхэд, чи Түүнийг Есүс гэж нэрлэ. Учир нь Тэр Өөрийн ард түмнийг нүглээс нь аварна гэж хэлэв. ²²Эдүгээ энэ бүхэн тохиолдсон нь Эзэн эш үзүүлэгчээр дамжуулан айлдсан нь биелэгдэхийн тулд бөгөөд ингэхдээ ²³“Харагтун, онгон бүсгүй Хүүхэдтэй болж Хүү төрүүлнэ. Тэгээд тэд Түүнийг Иммануел (орчуулбал “Бидэнтэй хамт буй Бурхан”) гэж нэрлэнэ” гэсэн юм. ²⁴Иосеф нойрноосоо сэрж, Эзэний тэнгэр элчийн тушааснаар Мариаг эхнэрээ болгоод, ²⁵Хүүг төрүүлтэл түүнийг онгон хэвээр нь

байлгасаар байв. Иосеф Түүнийг Есүс гэж нэрлэв. (Матай 1:18-25 АБ 2004)

[] Бүтээгч Бурхан хичээл зүтгэлтэй бөгөөд, дэлхий дээр эхлүүлсэн ажлаа дуусгаж байна. Та нар Түүний эсрэг талд биш харин Түүний талд зогсож байна уу?

[] Тэнгэр газрыг Бүтээгчийн хувьд бүх юм боломжтой гэдэгт та итгэдэг үү?

[] Бүх зүйл , онгон бүсгүйн төрөлт ч Бурханд боломжтой гэдэгт та итгэдэг үү?

[] Христ бол онгон бүсгүй Мариас мэндэлсэн гэж Бурханы үгэнд бичигдсэн байдаг. Та үүнд итгэдэг үү?

16.8 Дорно зүгийн мэргэд

⁴Иосеф Давидын удмын хүн байсан тул бас Галилын Назар хотоос Иудейг зорин Бетлехем гэгддэг Давидын хот уруу ⁵хүүхэдтэй болсон сүйт бүсгүй Мариагийнхаа хамт бүртгүүлэхээр явав. ⁶Тэднийг тэнд байх үед Мариагийн нярайлах өдөр нь болж, ⁷тэр ууган хүүгээ төрүүлж, Түүнийг даавуунд ороож гэжээлийн тэвшин дотор тавив. Учир нь дэн буудалд тэднийг хоноглуулахерөө байсангүй. (Лук 1:4-7 АБ 2004)

¹Херод хааны өдрүүдэд Иудейн Бетлехем хотод Есүсийг төрсний дараа дорно зүгээс зурхайчид Иерусалимд хүрч ирээд (Матай 2:1 АБ 2004)

[] Бурхан яагаад Мессиаг Бетлехемд төрсөн хүүхэд байхаар илгээснийг та мэдэх үү?